

## Гадаадын иргэдэд зориулсан орчуулагч

© Хэрэв таны эх хэл солонгос хэл биш бол шүүх хуралд хуулийн өмгөөлөгч авах шаардлагатай. Шүүхээс таны хүсэлтийн дагуу орчуулагч байлцуулж болох ба таны хүсэлтгүйгээр ч байлцуулж болно. Орчуулагчийн төлбөрийг та өөрөө төлөх үүрэгтэй.

© Мөн, та өөрийн орчуулагчаа шүүхэд дагуулж ирж болох ба ерөнхий шүүгч зөвшөөрсөн тохиолдолд **орчуулагчаа** байлцуулж болно. Энэ тохиолдолд шүүхэд орчуулагчийн хөлс төлөх шаардлагагүй бөгөөд харин орчуулагч биеийн байцаалтаа авч ирэх үүрэгтэй.

© Та өөрөө орчуулагч авч ирэх боломжгүй, орчуулагчийн хөлсийг төлөх боломжгүй тохиолдолд шүүхээс таны нөхцөл байдал хүсэлтийг харгалзан үзсэний үндсэн дээр орчуулагчийн хөлсийг **хөрөнгө мөнгөний бололцоогүй иргэдэд хууль эрхийн үйлчилгээ үзүүлэх**(улсаас төлбөрийг нь төлж тусалдаг) үйлчилгээнд хамруулж болно. Мөн орчуулагчийн хөлснөөс гадна шуудан, марк бусад төлбөр болон өмгөөлөгчийн хөлсийг ч төлж өгөх боломжтой.

© Мөн Сөүл хотын гэр бүлийн хэрэг шийдвэрлэх ерөнхий шүүхэд **сайн дурын орчуулагч**(англи, хятад, япон) нар ажиллаж байна. Шүүх хурлын талаар мэдээллийг эдгээр сайн дурын ажилчдаас авах боломжтой.(Эдгээр сайн дурын орчуулагчид нь мэргэжлийн хуулийн орчуулагч биш бөгөөд мэдээлэл хүргэх зорилготой сайн дурын хүмүүс).

[☎ : 02-530-2568]

© Доор буй хүснэгт нь солонгосоор сайн ойлголцох боломжгүй гадаадын иргэд орчуулагчгүйгээр шүүх хуралд оролцохоос сэргийлэн шүүх хурлыг ёс журмын дагуу явуулах зорилготой болно. Үүнд:

Дараах асуултын хариултуудыг шүүх хурлын өмнө өгнө үү. (Гагцхүү, Та солонгос хэлээр чөлөөтэй ойлголцдог эсвэл орчуулагчтайгаа хамт ирсэн бол бөглөхгүй байж болно). Үүнд:

Хэргийн дугаар :

Овог нэр:

Та ямар хэлээр ярьдаг вэ?	<input type="checkbox"/> Орос <input type="checkbox"/> Монгол <input type="checkbox"/> Вьетнам <input type="checkbox"/> Англи <input type="checkbox"/> Япон <input type="checkbox"/> Хятад <input type="checkbox"/> Тайланд <input type="checkbox"/> бусад( )
Таны солонгос хэлний төвшин ?	<input type="checkbox"/> Бие дааж ойлголцох боломжтой <input type="checkbox"/> Орчуулагчгүйгээр ойлголцох боломжгүй
Орчуулагч байлцуулах боломжтой юу?	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй (Орчуулагчийн утасны дугаар : )  (Орчуулагчтай ямар холбоотой : )
<b>‘Орчуулагч байлцуулах боломжгүй бол доорх хүснэгтийг бөглөнө үү.</b>	
Хуулийн мэргэжлийн өмгөөлөгч шаардлагатай юу?	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй
Орчуулагчийн хөлсийг төлүүлэх шаардлагатай юу?	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй